



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2022 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 8/13

Шивээговь сум

**Б.Даваадолгорт ур чадварын
 нэмэгдэл олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 4 дэх заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/35/А/10/9 дугаар хамтарсан тушаал “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай”-ын 8, 10 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ:**

1. Эрхэлсэн ажилдаа идэвх зүтгэл гарган удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, Гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг цаг тухайд нь хангаж, санаачлагатай ажилласан 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Бүдээбатын Даваадолгорт үндсэн цалингийн 15%-иар ур чадварын нэмэгдэл олгосугай.

2. Б.Даваадолгорт олгох нэмэгдлийг Цалингийн зардлаас дээр дурдсан хувиар бодож олгохыг 3 дугаар цэцэрлэгийн нягтлан бодогч (Ц.Пүрэвням)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ